



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 377

Улаанбаатар хот

“Төрийн орон сууцны корпораци”
хязгаарлагдмал хариуцлагатай компанийн
Төлөөлөн удирдах зөвлөлд
төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх
гишүүдийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.10, 4.1.3 дахь заалт, компанийн дүрмийн 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 01/3380 дугаар албан бичиг, Авилгатай тэмцэх газрын 2019 оны 05/5573 тоот албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан “Төрийн орон сууцны корпораци” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр Барилга, хот байгуулалтын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Н.Нарантуяаг 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн томилсугай.

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР